

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА,  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ-2021**

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг тоо баримтаар товч бичих	Байгууллагын үнэлгээ	Аймгийн ЗДТГазар үнэлгээ
<b>Хоёр. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хүлээсэн төрийн байгууллагын нийтлэг үүрэг</b>					
	2.1. Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1. Улсын Их Хуралд хэлэлцэгдэх хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх бололцоо, нөхцөлөөр хангах.	2.1.1. Үйл ажиллагаандаа ашиглаж буй цахим хуудас албан ёсны сайтад, хэлэлцэгдэж буй хууль, шийдвэрийн төслийг байршуулж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн зүгээс санал, хүсэлт илэрхийлэх бололцоог бүрдүүлэх.	2021 онд тус газраас нийтээр дагаж мөрдөх журам боловсруулаагүй.	100	
		2.1.2. Авлигатай тэмцэх газраас АТҮХөтөлбөрийн биелэлтийг байгууллагын цахим хуудсанд нэвтрэн үнэлж, дүгнэх болсонтой холбогдуулан төрийн байгууллагууд хийж хэрэгжүүлсэн ажлаа тухай бүр байгууллагын цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулах.	Авлигын эсрэг хууль болон дагаж мөрдөж дүрэм журам, зөвлөмжүүд болон хийж хэрэгжүүлсэн ажлын талаар тухай бүр байгууллагын хуудсанд байршуулж, албан хаагчдыг мэдээллээр ханган ажиллалаа.	100	
	2.2. Авлигын эсрэг хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2. Төрийн байгууллага Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах.	2.2.1. Байгууллагын цахим хуудсанд авлигын эсрэг 2021 оны төлөвлөгөө, иргэд болон хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудад зориулсан шаардлагатай гарын авлага, тараах материал бусад мэдээллийг бэлтгэн байршуулж, тогтмол шинэчлэх.	Байгууллагын цахим хуудсанд авлигын эсрэг төлөвлөгөө, АТГ-аас иргэд болон хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудад зориулан гаргасан гарын авлага, тараах материал, видео шторкуудыг байршуулсан.	100	
		2.2.2. Авлигын эсрэг хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулиудаар үүссэн нөхцөл байдалтай уялдуулан онлайн аар сургалт мэдээлэл өгөх, гарын авлага, шторкыг олон нийтийн сүлжээгээр тараах.	АТГ-аас зохион байгуулсан онлайн болон танхимын сургалтанд холбогдох албан тушаалтныг хамруулж, гарын авлага, шторкыг олон нийтийн сүлжээгээр тарааж иргэдэд хүргэж байна.	100	

<p>2.3. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3. Төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах.</p>	<p>2.3.1. Төрийн хяналт шалтгалтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах.</p>	<p>Аймгийн Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газартай 2021 онд хамтран хэрэгжүүлэх хяналт шалгалтын төлөвлөгөөг батлуулж, байгууллагын цахим хуудсанд байршуулан хэрэгжилтийг ханган ажиллаа. Аймгийн хэмжээнд хүрээлэн буй орчны эсрэг 155 зөрчил илрүүлж 3 байгууллага, 109 иргэнд нийт 45.6 сая төгрөгийн торгууль оногдуулж, байгаль орчинд учирсан хохирлын 39.2 сая төгрөгийг нөхөн төлүүлж, хууль бусаар олсон 1 цагаан зээр, 1 ширхэг мануул, 91 ширхэг тарваганы нойтон мах, 20 ширхэг калибр буу, 1 ширхэг мотоцикл, 90 кг байгалийн ургамал, 395 ширхэг хэрэглээний сургааг, 620 кг байгалийн өнгөт чулуу хурааж, 28 ширхэг ногтруу шувууг байгальд нь тавьсан байна. Тус газраас ойгоос мод бэлтгэх журам зөрчиж зохих зөвшөөрөл, эрхийн бичиггүй мод бэлтгэж тээвэрлэсэн зөрчил, хууль бусаар ан амьтан агнасан зөрчлийн хэргүүдэд экологи эдийн засгийн үнэлгээг гаргаж ажиллалаа.</p>	<p>100</p>	
<p>2.4. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4. Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх.</p>	<p>2.4.1. Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл болон төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухай бүр цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулах.</p>	<p>Байгууллагын тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл болон төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг тухай бүр цахим хуудсанд болон мэдээллийн самбарт байршуулсан.</p>	<p>100</p>	
	<p>2.4.2. Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгох. (татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээлэл) Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарын хамт мэдээлэх.</p>	<p>Байгууллагын төсөв ил тод нээлттэй байршуулж, шилэн дансны мэдээллийг тухай бүр оруулж ажилласан.</p>	<p>100</p>	
	<p>2.4.3. Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг нийтэд мэдээлэх.</p>	<p>Байгууллагын 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн аудитаар зөрчилгүй үнэлгээ авсан бөгөөд аудитын дүгнэлтийг мэдээллийн самбарт байршуулсан.</p>	<p>100</p>	
<p>2.7. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар</p>	<p>2.7.1. Иргэдийн өргөдөл (санал, мэдэгдэл), гомдол, хүсэлт, мэдээлэл гомдлыг хүлээн</p>	<p>Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч архив албан хэрэг</p>	<p>100</p>	

<p>зүйлийн 6.1.10. Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх энэ чиглэлээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх.</p>	<p>авах нөхцөлийг бүрдүүлэх. (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)</p>	<p>хөтлөлтийн программд оруулж холбогдох албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлэлтэнд хяналт тавин ажиллаа. Шийдвэрлэлтийн талаарх тайланг улирал бүр гаргаж АЗДТГ-ын ТЗУХэлтэст хүргүүлсэн. Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах хайрцаг ажиллуулж, мөн цахимаар хүлээн авч байна.</p>		
<p>2.8. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.10. Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан хууль ёсны шаардлага, шийдвэрийг хүлээн авсан аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан түүний дагуу холбогдох арга хэмжээг заавал авч, хариуг хугацаанд нь өгөх үүрэгтэй.</p>	<p>2.8.1 Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд аймгийн ЗДТГазраас хүргүүлсэн хугацаатай албан бичгийн биелэлтийг заасан хугацаанд нь хүргүүлэх, зөвлөмжтэй холбогдуулан зохион байгуулалтын арга хэмжээ авах.</p>	<p>Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд аймгийн ЗДТГазраас хүргүүлсэн хугацаатай албан бичгийн биелэлтийг заасан хугацаанд тухай бүр гаргаж тайлагнасан.</p>	100	
	<p>2.8.2. Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагчаас /аймгийн Засаг даргаас/ гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах мэдэгдэл болон хууль, журмын хүрээнд хариуцлага тооцож, арга хэмжээ авахуулахаар ирүүлсэн албан бичгийн биелэлтийг тус тус шийдвэрлэн хугацаанд нь хүргүүлэх.</p>	<p>Мэдэгдэл ирээгүй.</p>	100	
<p>2.10. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10-22</p>	<p>2.10.1. Хуулийн 10 дугаар зүйлийн 10-22 дугаар зүйлүүдэд заасан албан тушаалтанд тавигдах 13 төрлийн хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарч, албан тушаалтны ХАСУМ-ийг хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалтанд зөвлөмж чиглэл хүргүүлж ажиллах.</p>	<p>ТЗ-6 ангиллаас дээш албан тушаалтан шинээр томилсон тохиолдолд тушаалтны ХАСУМ-ийг гаргуулж, АТГ-т уламжлан хянасан дүгнэлтийг үндэслэн томилгоо хийж байна. Хуулийн 10 дугаар зүйлийн 10-22 дугаар зүйлүүдэд заасан албан тушаалтанд тавигдах 13 төрлийн хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах тал дээр заавар зөвлөмж өгч хэрэгжилтийг ханган ажиллалаа.</p>	100	

дугаар зүйлүүдэд заасан албан тушаалтанд тавигдах хориглолт хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах.	2.10.2. Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг /шинэчлэн болон шинээр томилогдсон албан тушаалтнуудын/ үнэн зөв, хуульд заасан хугацаанд гаргуулах, бүртгэх, хянах, үйл ажиллагаа зохион байгуулах.	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг холбогдох албан тушаалтнууд үнэн зөв гаргаж, хуулийн хугацаанд мэдүүлсэн.	100	
	2.10.3. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, цахим системд бүртгэх.	Байгууллагын худалдан авах ажиллагаа болон газрын даргын шийдвэрүүдэд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг гаргуулж шилэн дансанд тухай бүр байршуулсан.	100	
<b>ДУНДАЖ ОНОО</b>			100	
<b>Гурав. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд</b>				
Зорилт 1. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх.				
3.1. Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх.	3.1.1. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх.	Албан тушаалын томилгоо хийхдээ албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг хангасан иргэдийг холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн томилж, дэвшүүлж ажилласан.	100	
	3.1.2. Төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг тухай бүрд олон нийтэд ил тод болгох.	Томилгоо хийгдээгүй.	-	
	3.1.3. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн баримтад хүргүүлэх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн тогтоол, дүгнэлтийг хавсаргах.	-	-	

<p>3.2.Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах, нийтийн албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх.</p>	<p>3.2.1. Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах.</p>	<p>2021 онд тус газрын албан хаагчид хариуцсан ажлын чиглэлээр 32, Төрийн албаны зөвлөлийн арга зүйн цуврал сургалтад 16 удаа, Удирдлагын академийн богино хугацааны зорилтот сургалтад 2 мэргэжилтэн тус тус онлайнаар хамрагдаж, магистрын хөтөлбөрт 1, докторантурт 1 мэргэжилтэн суралцлаа.</p>	<p>100</p>	
<p>3.3. Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх.</p>	<p>3.3.1. Төрийн байгууллагын ёс зүйн хорооны үйл ажиллагааг идэвхжүүлэх.</p>	<p>Байгууллагын хэмжээнд ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах байгууллагын Ёс зүйн зөвлөлийг ажиллуулж, төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний талаар холбогдох зорилт арга хэмжээг тусгаж хэрэгжилтийг тооцон ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлөөс төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулах чиглэлээр гарсан заавар зөвлөмжийг байгууллагын цахим хуудаст тухай бүр байршуулж, төрийн албан хаагчдад танилцуулж ажилласнаар 2021 онд тус газрын төрийн албан хаагчдаас ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй болно.</p>	<p>100</p>	
	<p>3.3.2. Төрийн байгууллагуудын дотоод хяналт шалгалтын нэгжийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих.</p>	<p>Тус газрын дотоод хяналтын нэгжийн 2022 оны төлөвлөгөөг гаргаж батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Төлөвлөгөөнд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд: -Тус газрын харъяа Сум дундын Ойн ангийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт, зөвлөн туслах ажил зохион байгуулах удирдамжийг газрын даргаар батлуулж 2021 оны 10 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд газар дээр нь очиж ажилласан. Дотоод хяналт шалтгалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээ, зөвлөмжийг газрын даргын 2021 оны</p>	<p>100</p>	

			<p>12 дугаар сарын 13-ны өдийн 105 дугаар албан тоотоор Сум дундын ойн ангид хүргүүлсэн.</p> <p>-2020 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ажлын санхүүгийн баримтад дотоод хяналт шалгалт хийж дүн мэдээг байгууллагын удирдлагад танилцуулсан.</p> <p>-Аймгийн Засаг даргын 2021 оны А/337 дугаар захирамжаар байгуулагдсан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн ажлыг хүлээн авах ажлын хэсэгт дотоод хяналтын нэгжийн төлөөллийг оролцуулж, хяналт тавьж ажиллалаа.</p> <p>-Тус газрын мэргэжилтнүүд болон сумдын байгаль хамгаалагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсээр үнэлж дүгнэн, дүн мэдээг удирлагад танилцуулж баталгаажуулсан.</p>		
Зорилт 2. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх.					
	3.4. Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх.	3.4.1.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах.	Тус газраас иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний ажил үйлчилгээний жагсаалтыг гаргаж байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын бэлтгэл хийгдэж, 2022 онд E-Mongolia- сиемд оруулах жил хийгдэнэ.	100	

<p>3.6.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах.</p>	<p>3.6.3. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, хэрэгжүүлэх.</p>	<p>Төрийн албан хаагчдын ажил үйлчилгээтэй холбоотой тэдний харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой санал асуулгыг түүврийн хэлбэрээр авч ажил дүгнэхэд шалгуур үзүүлэлт болгож байна.</p>	<p>100</p>	
<p>Зорилт 4.Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх.</p>				
<p>3.9. Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх.</p>	<p>3.9.1. Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах, цаашид тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулж хэвшүүлэх.</p>	<p>2021 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд байгууллагын худалдан авалтын төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд гаргаж Сангийн ямаар батлуулсан. Тус төлөвлөгөөнд 4 арга хэмжээг тендер сонгон шалгаруулалтаар, 14 арга хэмжээг шууд худалдан авалтаар зохион байгуулахаар төлөвлөж худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтын дагуу зохион байгуулан уг тендерүүдийн урилга болон шалгаруулалтын үр дүнг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> сайтад байршуулан шалгаруулалтыг цахимаар зохион байгуулсан. Шууд худалдан авах бараа ажил үйлчилгээний жагсаалтыг газрын даргын тушаалаар батлаж, шилэн дансанд байршуулсан.</p>	<p>100</p>	
	<p>3.9.2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах.</p>	<p>Аудит хийгдээгүй</p>	<p>-</p>	

	3.9.3. Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг цахим хуудсанд байршуулж мэдээлэх.	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хүрээнд зарлагдсан тендерүүдэд шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг тухай бүр <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> сайтад байршуулсан.	100	
--	--	--	-----	--

Хүснэгт-2

д/д	Төлөвлөгөөний хүрээнд гүйцэтгэсэн ажлын төрөл	Хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг тоо баримтаар товч дурьдах		
1	Сум, байгууллагын албан ёсны ямар вэб сайтад авлигын эсрэг хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, мэдээ, мэдээлэл, жилийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг байршуулсан талаар /цахим хуудас хаяг нэр/	<a href="http://www.Uvurkhangainature.com">www.Uvurkhangainature.com</a> Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар пэйж хуудас		
2	Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гаргасан шийдвэр /тоо/	11		
3	Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө	-		
4	Зохион байгуулсан цахим сургалтын тоо	1		
5	Зохион байгуулсан танхимын сургалтын тоо	1		
6	Цахим болон танхимын сургалтанд хамрагдсан удирдах албан тушаалтан, төрийн албан хаагч, иргэдийн тоо	1.Удирдах албан тушаалтны тоо-2 2.Төрийн албан хаагчийн тоо-87 Нийт тоо-89		
7	Авлигын хууль тогтоомжийн чиглэлээр тараасан гарын авлага, тараах материалын тоо			
8	Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулага, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг материал г.м/	8		
9	АТҮхөтөлбөр болон Авлигын эсрэг үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр гарсан өөрчлөлт, ач холбогдол, үр дүн	Авилга ашиг сонирхлын зөрчил гаргасан албан хаагч байхгүй.		

ХЯНАСАН:

ДАРГА

Г.БАЯСГАЛАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ-ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЗОЛЗАЯА



